

## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2018 оны 6 дугаар сарын 04-ны өдөр

№ 13/13

Улаанбаатар хот

### **Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны тухай**









Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.13 дахь хэсэг, 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, 81 дүгээр зүйл, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.1, 10.1, 13.1, 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Очирсүрэнгийн Болдбаатарыг сонгосугай.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргаар Чинбаатарын Намирааг томилсугай.
3. Компанийн “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
  - 4.1 Дарга Дүгэрсүрэнгийн Бат-Очир;
  - 4.2 Гишүүн Володьягийн Баярсайхан;
  - 4.3 Гишүүн Сүрэнхүүгийн Боргил;
  - 4.4 Гишүүн Сэнгээгийн Энх-Амгалан;
  - 4.5 Гишүүн Нармандахын Цэвэгмид.
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
  - 5.1 Дарга Жигдэнгийн Жаргалсүрэн (хараат бус гишүүн);
  - 5.2 Гишүүн Булганы Гантулга;
  - 5.3 Гишүүн Очирсүрэнгийн Болдбаатар.
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
  - 6.1 Дарга Очирсүрэнгийн Болдбаатар;
  - 6.2 Гишүүн Булганы Гантулга;
  - 6.3 Гишүүн Сүрэнхүүгийн Боргил.
7. Шинээр сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн Гүйцэтгэх захирал /Б.Дэлгэржаргал/-ын бүрэн эрх буюу түүнтэй байгуулсан гэрээг батламжилж байгааг дурдсугай.
8. Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.



**ТУЗ-ИЙН ГИШҮҮД:**

- |  |                |   |                  |
|--|----------------|---|------------------|
| <br>..... | /Д.БАТ-ОЧИР/   | <br>..... | /С.ЭНХ-АМГАЛАН/  |
| <br>..... | /О.БОЛДБААТАР/ | <br>..... | /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/ |
| <br>..... | /В.БАЯРСАЙХАН/ | <br>..... | /Ж.ЖАРГАЛСҮРЭН/  |
| <br>..... | /С.БОРГИЛ/     | <br>..... | /Н.ЦЭВЭГМИД/     |

# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар сарын 04-ны өдөр

№ 18/14

Улаанбаатар хот

## **Хаалттай бонд гаргах, Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.16 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.2, 9.6.19 дэх хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компаниас дараах нөхцөл бүхий хаалттай өрийн бичгийг гаргахаар шийдвэрлэсүгэй.
  - 1) **Нийт үнэ:** 5'000'000'000 (таван тэрбум) төгрөг хүртэл;
  - 2) **Хугацаа:** 1 (нэг) жил;
  - 3) **Хүү:** жилийн 17 (арван долоон) хувь хүртэл;
  - 4) **Хүү төлөх хугацаа:** 6 сар тутам;
  - 5) **Баталгаа:** Өөрийн хөрөнгө. Өрийн бичиг нь ямар нэгэн компани аж ахуйн нэгжээс тусгайлан гаргасан баталгаагүй болно.
  - 6) **Хугацаанаас өмнө буцаан худалдан авах:** Компани нь өрийн бичгийг хугацаанаас нь өмнө энд заасан нөхцөлөөр буцаан худалдан авах эрхтэй.
2. Мирэ Эссет Секьюритис Монгол Үнэт цаасны компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний дагуу гаргасан хаалттай өрийн бичгийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх шимтгэлийг тус компанид төлөхийг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хаалттай өрийн бичиг гаргах асуудлаар Үнэт цаасны компанитай хамтран ажиллах, хаалттай өрийн бичгийн худалдан авагчийн судалгааг Мирэ Эссет Секьюритис үнэт цаасны компани хариуцаж ажиллахыг хянах, гэрээний Боломжит худалдан авагчтай дээр дурдсан нөхцөлөөр Худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.
4. Хаалттай өрийн бичиг гаргаснаар татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ББСБ-ын зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.

### **ТУЗ-ИЙН ГИШҮҮД:**

ЛЭНДМН ББСБ ХХК

ЛЭНДМН

УЛААНБААТАР ХОТ  
УЛСЫН ХУУЛЬ  
10233672

..... /Д.БАТ-ОЧИР/

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

..... /О.БОЛДБААТАР/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /С.БОРГИЛ/

..... /Н.ЦЭВЭГМИД/